


**МОНГОЛ УЛС: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САР
ТУТМЫН ТОЙМ**

2016.04

Үзүүлэлтүүд:


ДНБ 3.2% 2016 оны I-р улирал урьдчилсан гүйцэтгэлээр	ГШХО 3-р сард 61.8 сая ам.доллар	Төсвийн тэнцэл -663.5 тэрбум төгрөг	Инфляци 2.1%	Чанаргүй зээл 1065 тэрбум төгрөг	Валютын нөөц 1.2 тэрбум ам.доллар
Уул уурхайн салбар 130.5 хувь, барилгын салбар 9.4 хувь, хөдөө аж ахуйн салбар 5 хувь тус тус өссөн нь нөлөөлөв.	Цэвэр ГШХО 3-р сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 93.6 сая ам.доллар, өмнөх сараас 36 сая ам.доллараар өсч 61.8 сая ам.доллар болов.	Төсвийн орлого 1656.3 тэрбум төгрөг зарлага 2319.9 тэрбум болж төгрөг, тэнцэл (663.5) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.	Өмнөх сараас 1.4 хувь, оны эхнээс 3.1, өмнөх оны мөн үеийнхээс 2.1 хувиар тус тус өслөө.	Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 10.3 хувь буюу 99 тэрбум төгрөгөөр өсч 1065 тэрбум төгрөгт хүрэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээл 9.1% байна.	Монголбанкны валютын нөөц 3-р сард өнгөрсөн оны мөн үеэс 4.4 хувь буюу 59 сая ам.доллараар буурч 1265 сая ам.доллар болов.
 Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2011.99 ₮	 Орон сууцны үнийн индекс 1.035 Өмнөх сараас 0.9%-иар, өмнөх оны мөн үеэс 11.1%-иар тус тус буурлаа.	 Монголбанкны бодлогын хүү 10.5 %			



АСЕМ-ийн Дээд түвшний уулзалтын хүрээнд Улаанбаатар хотноо зохиогдож буй Ази Европын парламентын түншлэлийн 9 дүгээр уулзалтын нээлтийн ажиллагаа төрийн ордны их танхимд боллоо. АЕПТ-ийн 9 дүгээр уулзалтад 32 орон болон Европын Парламентаас 170 орчим төлөөлөгч оролцов.

Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, хүснэгтээр оны эцсийн байдлаар үзүүлээ.



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд (Мянган ам.доллар, тонн)

Голлох бүтээгдэхүүн	2013 он		2014 он		2015 он	
	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар
Чулуун нүүрс	18,194	1,116,153	19,482	850,615	14,426	555,027
Төмрийн хүдэр	6725	654,333	8,338	448,378	6,325	227,200
Зэсийн баяжмал	650	948,951	1,378	2,575,636	1,379	2,280,135
Нийт	25,569	2,719,437	29,198	3,874,629	22,130	3,062,362

Эх сурвалж: Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газар

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны хуралдаанаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 240,000 төгрөг буюу 25 хувиар нэмэх шийдвэр гарч 2017 оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхлэхээр болов.


Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

ДНБ ДНБ 2016 оны 1-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 91.3 тэрбум төгрөгөөр өсч эдийн засгийн өсөлт 3.2 хувь болов. ДНБ-ий 3.2 хувиар өсөхөд 130.5 хувь нь уул уурхай, олборлох салбар, 9.4 хувь нь барилгын салбар, 5 хувь нь хөдөө аж ахуйн салбар 5.4 хувь нь үйлчилгээний бусад салбарын өсөлтөөс шалтгаалсан байна.



Төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ дөрөвдүгээр сард 1656.3 тэрбум төгрөг, зарлага, эргэж төлөгдөх зээлийн хэмжээ 2319.9 тэрбум төгрөг, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл (663.5) тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеийнхээс 418.8 тэрбум төгрөгөөр өсөхөд орлого 1.1 хувиар буурч, зарлага 20.8 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.




Валютын ханш

Дөрөвдүгээр сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 36.1 төгрөг буюу 1.8 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 36.9 төгрөг буюу 1.8 хувиар буурч 2011.99 төгрөгөөр сулрав.



Инфляци


Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2016 оны 4-р сард өмнөх сараас 1.4 хувь, өмнөх оны мөн үеэс 3.1 хувь өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2016 оны 4-р сард өмнөх оны мөн үеийнхнээс 2.1 хувиар өсөхөд 61.1 хувь нь боловсролын үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс, 26.5 хувь нь хувцас, бөс барааны үнийн өсөлтөөс үүсчээ.



* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж УБСЕГ, Монголбанк

Гадаад валютын нөөц


Гадаад валютын улсын албан нөөц 2016 оны 3-р сарын байдлаар 1265 сая ам.доллар болов. Энэ нь өмнөх сараас 5.6 хувь буюу 68 сая ам.доллараар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 4.4 хувь буюу 59 сая ам.доллараар буурсан байна.



* Эх сурвалж Монголбанк


MSE-20 индекс

2016 оны дөрөвдүгээр сард 46.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 10.2 сая ш үнэт цаас арилжигдсан нь өмнөх сарынхаас гүйлгээ 30.9 тэрбум төгрөг буюу 3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс гүйлгээ 229 тэрбум төгрөг буюу 83.1 хувиар буурч, арилжигдсан үнэт цаас өмнөх сарынхаас 9.7 сая ш буюу 19.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 8.9 сая ш буюу 7.6 хувиар өсчээ. ТОП-20 дундаж индекс 2016 оны 4-р сард 11019 нэгж болж, өмнөх сарынхаас 171 нэгж, өмнөх оны мөн үеийнхээс 2093 нэгжээр буурчээ.



*Монголын хөрөнгийн бирж

Мөнгө Мөнгөний нийлүүлэлт (M2) 2016 оны дөрөвдүгээр сарын эцэст 10.5 их наяд төгрөг болж, өмнөх сараас 404 тэрбум төгрөг буюу 4 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 813 тэрбум төгрөг буюу 8.3 хувиар өсөв. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө тайлант сард 745 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 86 тэрбум төгрөг буюу 13.1 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 10.1 тэрбум төгрөг буюу 1.3 хувиар өсчээ.




Хадгаламж Нийт хадгаламж 2016 оны 4-р сард 7.6 их наяд төгрөг болж өмнөх сараас 57.1 тэрбум төгрөг буюу 0.8 хувиар өссөн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 426 тэрбум төгрөг буюу 5.9 хувиар өссөн үзүүлэлт юм. Ийнхүү, өмнөх сараас нийт хадгаламж өсөхөд валютын хадгаламж 3 хувиар буюу 63.6 тэрбум төгрөгөөр өсч, төгрөгийн хадгаламж 0.1 хувиар буюу 6.4 тэрбум төгрөгөөр буурчээ.



Зээл ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2016 оны дөрөвдүгээр сарын байдлаар 11.6 их наяд төгрөг болж, өмнөх сараас 198 тэрбум төгрөг буюу 1.7 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 667 тэрбум төгрөг буюу 5.4 хувиар буурав. Харин чанаргүй зээлийн хэмжээ 1065 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 10.3 хувь (99 тэрбум төгрөг)-иар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 42.5 хувь 318 тэрбум төгрөг)-иар өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 9.1 хувийг эзэлж байна.




Ипотекийн зээл 2016 оны 3-р сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 3.1 хувь (105 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 18.2 хувь (550 тэрбум төгрөг)-өөр нэмэгдэж нийт 3.5 их наяд төгрөгт хүрэв. Гуравдугаар сард нийт 3342 зээлдэгчид 105.7 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 81015-д хүрэв. 2016 оны 3 дугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдэлийн 98.8 хувь нь төгрөгийн зээл, 1.2 хувь нь гадаад валютын зээл байна.



* Эх сурвалж Монголбанк

Гадаад худалдаа

Гадаад худалдаа 2016 оны дөрөвдүгээр сард худалдааны нийт бараа эргэлт 2210 сая ам.доллар, үүнээс экспорт 1347 сая ам.доллар, импорт 862 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 484 сая ам.долларын ашигтай гарлаа. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 276.5 сая ам.доллар буюу 11.4 хувь, үүний дотор экспортын хэмжээ 104.9 сая ам.доллар буюу 7 хувиар, импортын хэмжээ 102.6 сая ам.доллар буюу 16.5 хувиар тус тус буурчээ. Үүнд, эрдэс бүтээгдэхүүний экспорт 149.1 сая ам.доллар, машин тоног төхөөрөмж 11.6 сая ам.доллар, хүнсний бүтээгдэхүүн 9.3 сая ам.доллар, үндсэн төмөрлөг бүтээгдэхүүн 2 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлөв.



* Эх сурвалж УБСЕГ, Монголбанк

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 2016 оны гуравдугаар сард 61.8 сая ам.долларын эерэг үр дүнтэй гарлаа. Энэ нь өмнөх оны мөн үеэс 93.6 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Өмнөх сартай харьцуулахад 36 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтад МУ-аас гадаад руу гаргасан хөрөнгө оруулалт -1 сая ам.доллар байсан бол Монгол Улсад 62.8 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ.



* Эх сурвалж Монголбанк


Монгол Улсын гадаад өр

Гадаад өр

2015 оны дөрөвдүгээр улиралд Засгийн газрын нийт гадаад өр 3.6 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 21.6 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 3 хувь (107.3 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 0.5 хувь (120 сая ам.доллар)-аар тус тус буурсан байна. Тайлант улиралд нийт Улсын гадаад өрийн 17 хувийг засгийн газрын өр, 9 хувийг Төв банкны өр, 9 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 16 хувийг бусад салбаруудын өр, 49 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна. Төв банкны нийт өрийн 96 хувийг богино хугацаат, 4 хувийг урт хугацаат өглөг эзэлж байна.



МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨРИЙН БҮТЭЦ ХУВИАР



* Эх сурвалж Монголбанк

Засгийн газрын гадаад өрийн 2015-2017 оны төсөөлөл

Үзүүлэлтүүд	2014.09.3 Гүйцэтгэл	2015 он	2016 он	Тэрбум төгрөг
				2017 он
ЗГ-ын гадаад зээлийн өр	3,911.50	4,089.20	4,299.10	4,169.30
ЗГ-ын гадаад үнэт цаасны өр	2,760.80	2,625.00	2,550.00	2,490.00
Засгийн газрын баталгаа	2,305.50	2,515.80	2,439.20	1,312.50
Засгийн газрын гадаад өрийн дүн	8,977.80	9,230.00	9,288.30	7,971.80

* Эх сурвалж Сангийн яамнаас гаргадаг тайлан мэдээ

Гадаад өр, зээлжих зэрэглэл

Зээлжих зэрэглэл	S&P		Fitch	
	Монгол Улс	Тогтвортой	В	Сөрөг
Огноо	2015.11.05		2013.12.13	

Standard & Poor's Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 11-р сард "B+" зэрэглэлээс "B" зэрэглэлд болгож бууруулав. Монгол Улсын зээлжих зэрэглэл буурсан шалтгааныг тэд гадаадын хөрөнгө оруулалт буурсан, гадаад валютын урсгал багассан, өрийн ачаалал үүсч болох эрсдэлт нөхцөл үүссэнтэй холбон тайлбарлаж байна.

Moody's :

Moody's агентлаг нь зээлжих зэрэглэлийг тогтооходоо C ангиллаас AAA хүртэл 21 ангилалд зэрэглэл тогтоодог ба мөн хэтийн төлөвийг сөрөг, тогтвортой гэж үнэлдэг.

Огноо	Зээлжих зэрэглэл	Хэтийн төлөв
2005 оны 10 дугаар сар 4-нд	B1	Тогтвортой
2009 оны 6 дугаар сарын 10-нд	B1	Сөрөг
2009 оны 10 дугаар сарын 30-нд	B1	Тогтвортой
2014 оны 5 дугаар сарын 26-нд	B1	Сөрөг
2014 оны 7 дугаар сарын 17-нд	B2	Сөрөг

Moody's 2014 оны 7-р сард Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулсан.

Moody's агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг B1 -ээс B2 сөрөг болгож бууруулсан. Үүний шалтгааныг Монгол Улсын гадаад өрийн хэмжээ сүүлийн жилүүдэд огцом өссөн, инфляци өндөр байгаа нь чанаргүй зээлийн хэмжээг нэмэгдүүлж, банкны системийг бүхэлд нь эрсдэлд оруулах магадлалтай гэж үзжээ. Түүнчлэн гадаад валютын нөөц буурч байгааг эрсдэлд тооцжээ.

Үүний зэрэгцээ Moody's засгийн газрын үнэт цаас гаргагч ба бондын үнэлгээг B1, засгийн газрын дунд хугацаат өрийн бичгийн үнэлгээг B1, мөн богино хугацааны үнэлгээг "not prime" буюу төлбөрийн чадвар сул зэрэглэлд хэвээр үлдээсэн.

- 04.05-08** Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг 2016 оны дөрөвдүгээр сарын 5-8-ны өдрүүдэд БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгт зохион байгуулагдсан Азийн хөрөнгө оруулалтын чуулга уулзалтад оролцлоо.
- 04.14** Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэнгийн урилгаар ОХУ-ын Гадаад хэргийн сайд Сергей Лавров энэ 14-ний өдөр Монгол Улсад албан ёсны нэг өдрийн айлчлал хийлээ.Оросын Холбооны Улсын Гадаад хэргийн сайд С.В.Лавровыг Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг хүлээн авч уулзлаа.
- 04.18-22** Монгол Улсын их хурлын дарга З.Энхболдын урилгаар Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Лок Сабхагийн дарга, хатагтай Сумитра Махажан болон Энэтхэгийн Парламентын төлөөлөгчид Монголд албан ёсны айлчлал хийлээ.

Тойм

300 сая ам.долларын гэрээ байгуулав.

Хөгжлийн банк ОХУ-ын ВТБ банктай 300 сая ам.долларын эх үүсвэрийг гэрээг байгуулав. Тус банкнаас бүрдүүлсэн эх үүсвэрийг 7.6 хувийн хүүтэйгээр авч буй бөгөөд ОХУ-аас газрын тосны бүтээгдэхүүн импортлогч, аж ахуй нэгжид тогтвортой санхүүжилтийг бий болгохоор ажиллаж байна. Дээрх санхүүжилтийн гэрээ 3 жилийн хугацаатай үргэлжлэх бөгөөд манай улсын нефтийн импортын хэмжээтэй уялдуулан санхүүжилтийг хэсэгчлэн авахаар тооцоолжээ.

2016 оны эхний улиралд 1.8 тонн алт олборлов.

Манай улс эхний 3 сарын байдлаар 5.2 сая тонн нүүрс, 1.8 тн алт, 305.2 мянган тонн газрын тос олборложээ. 37.3 мянган тонн хайлуур жоншны баяжмал, 379.9 мянган тонн зэсийн хүдрийн баяжмал, 133.9 мянган тонн төмрийн хүдрийн баяжмал, 21.8 мянган тонн цайрын баяжмал тус тус үйлдвэрлэсэн байна. Мөн эхний 3 сарын байдлаар 412.8 мянган тонн зэсийн баяжмал, 991.7 мянган тонн төмрийн хүдэр, 2.9 тонн алт, 3.3 сая тонн нүүрс экспортложээ.